МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

"ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАРАЛТАЙ БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН БИРЖ" ТӨСӨЛ

# ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАРАЛТАЙ БАРАА,ТҮҮХИЙ ЭДИЙН БИРЖ

## Гарын авлага

## I

Улаанбаатар хот
2012

ГАРЧИГ


1. Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль ........................................................................ 3
2. Монгол Улсын Их Хурлын 29 дүгээр тогтоол.......................17
3. Монгол Улсын Засгийн Газрын 235 дугаар тогтоол............ 19
4. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаал ................................................................................................ 24
5. Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн 100 асуулт,хариулт................................................................25
6. Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн нэгжийн танилцуулга............................................................ 50

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 06 сарын 02 өдөр
Төрийн ордон, Улаанбаатар хот

## ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАРАЛТАЙ БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН БИРЖИЙН ТУХАЙ

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
## НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийг үүсгэн байгуулах, түүний зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох, хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийг бэлтгэн нийлүүлэх, хадгалах, тээвэрлэх, биржээр арилжихтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

### 2 дугаар зүйл. Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль тогтоомж

2.1.Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль[1],

1 Монгол Улсын Үндсэн хууль – “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.

[2] Иргэний хууль – “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

Иргэний хууль[2], Төрийн болон орон нутгийн өмчийн тухай[3], Компанийн тухай[4], Үнэт цаасны зах зээлийн тухай хууль[5], энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

### 3 дугаар зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн бирж” /цаашид “бирж” гэх/ гэж хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн арилжааг тогтсон журмын дагуу зориулалтын байранд, эсхүл цахим сүлжээгээр болон энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан биржийн арилжааны төрөл, хэлбэрээр зохион байгуулдаг компанийг;

3.1.2.“биржээр арилжих хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эд” /цаашид “бараа, түүхий эд” гэх/ гэж биржээр арилжих барааны жагсаалтад орсон, гарал үүсэл, чанарын гэрчилгээтэй, биржийн гэрээний стандартыг хангасан бараа, түүхий эдийг;

3.1.3.“биржийн арилжаанд оролцогч” гэж биржид бараа, түүхий эд арилжих зорилгоор бүртгүүлсэн, биржийн арилжаанд

[3]Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль – “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1996 оны 11 дүгээрт нийтлэгдсэн.

[4] Компанийн тухай хууль – “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1999 оны 34 дүгээрт нийтлэгдсэн.

[5]Үнэт цаасны зах зээлийн тухай хууль – “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2002 оны 48 дугаарт нийтлэгдсэн.

оролцох зөвшөөрөлтэй хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл эрхлэгчдээс бүрдсэн хоршоо, биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийг;

3.1.4.”биржийн арилжааны зах зээлд оролцогч” гэж бараа, түүхий эдийг бэлтгэх, үйлдвэрлэх, чанар, тоо хэмжээг тодорхойлох, хадгалах, тээвэрлэх, зуучлан арилжих, биржийн арилжааг зохион байгуулах, төлбөр тооцоог гүйцэтгэх, гарал үүслийг гэрчлэх, экспортлох үйл ажиллагааг эрхэлж байгаа этгээдийг;

3.1.5.“биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа” гэж бараа, түүхий эдийг гэрээний үндсэн дээр биржээр зуучлан арилжих ажиллагааг;

3.1.6.“биржийн арилжаа” гэж биржийн арилжаанд оролцогчдын хооронд байгуулах гэрээний үндсэн дээр бараа, түүхий эдийг худалдах, худалдан авах үйл ажиллагааг;

3.1.7.“биржийн дэнчин” гэж биржийн арилжааны зуучлагч /брокер/ нь гэрээгээр хүлээсэн төлбөрийн үүргээ хэрэгжүүлэх баталгаа болгон энэ хуулийн 6.1-д заасан байгууллага дахь өөрийн дансанд урьдчилан байршуулсан мөнгийг;

3.1.8.“суудлын эрх” гэж биржийн арилжаанд тогтмол оролцох эрхийг.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ
## БИРЖ, ТҮҮНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 4 дүгээр зүйл.Бирж

4.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн арилжааг зохион байгуулах төрөлжсөн нэг бирж үйл ажиллагаа явуулна.

4.2.Бирж нь биржийн арилжааг зохион байгуулахдаа бие

даасан, нээлттэй, ил тод, хараат бус байх үндсэн зарчмыг баримтална.

4.3.Бирж нь зориулалтын байр, төвлөрсөн мэдээллийн сантай байх бөгөөд биржийн арилжааг зохион байгуулах программ хангамж, сүлжээний найдвартай байдлыг хангасан байна.

4.4.Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа биржийн арилжаанд оролцогч нь цахим сүлжээгээр дамжуулан биржийн арилжаанд шууд оролцож болно.

4.5.Биржээр арилжих бараа, түүхий эдийн жагсаалт, бараа, түүхий эдийг коджуулах журмыг хөдөө аж ахуй, худалдааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

4.6.Энэ хуулийн 4.5-д заасан жагсаалтад орсон бараа, түүхий эдийг экспортод гаргахдаа биржээр арилжаалсан байна.

4.7.Бараа, түүхий эдийг биржийн арилжаанд оролцож худалдан авсан тухай тодорхойлолтыг үндэслэн дор дурдсан иргэн, хуулийн этгээдэд урамшуулал олгох журмыг хөдөө аж ахуй, худалдааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална:

4.7.1.хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл эрхлэгчдээс бүрдсэн хоршоо /цаашид “хоршоо” гэх/-ны гишүүн;

4.7.2.газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч.

4.8.Биржээс гадуурх бараа, түүхий эдийн арилжаанд биржийн нэр ашиглахыг хориглоно.

4.9.Биржийн арилжаанд оролцох тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага болон биржийн үйл ажиллагаанд хяналт тавих журмыг Санхүүгийн зохицуулах хороо батална.

4.10.Энэ хуулийн 4.5, 5.1.7-д заасан жагсаалтад орсон бараа, түүхий эдийг төсвийн хөрөнгөөр худалдан авах бол биржээр дамжуулна.

4.11.Бирж нь өөрийн нэрийн өмнөөс болон бусад оролцогчийн нэрийн өмнөөс биржийн арилжаанд оролцохыг хориглоно.

**5 дугаар зүйл.Биржийн чиг үүрэг**

5.1.Бирж нь дараах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ:

5.1.1.биржийн арилжааг зохион байгуулах;

5.1.2.биржийн байнгын гишүүн оролцогчид суудлын эрх олгох;

5.1.3.биржийн байнгын бус гишүүн оролцогчид биржийн арилжаанд оролцох зөвшөөрөл олгох;

5.1.4.энэ хуулийн 4.5-д заасан жагсаалтад орсон бараа, түүхий эдийг экспортод гаргах тохиолдолд биржээр арилжсан тухай тодорхойлолтыг Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай хуульд[6] заасан экспортын барааны гарал үүслийг гэрчлэх эрх бүхий байгууллагад хүргүүлэх;

5.1.5.биржийн арилжаанд оролцогчийг сургах, мэргэшүүлэх, итгэмжлэл олгох;

5.1.6.биржийн арилжаанд оролцогчийг шаардлагатай мэдээллээр хангах;

5.1.7.энэ хуулийн 4.5-д заасан жагсаалтад орсноос бусад нэр төрлийн бараа, түүхий эдийг биржээр арилжих жагсаалтыг батлах;

5.1.8.биржийн арилжаанд оролцогчийн хүсэлтээр бараа, түүхий эдийн чанар, тоо хэмжээг хянан баталгаажуулж магадлагаа гаргах;

5.1.9.биржийн арилжааны явцад зохиомлоор үнэ өсгөх,

---

6 Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль –“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1996 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.

бууруулах оролдлого хийж байгаа эсэхэд хяналт тавих, таслан зогсоох;

5.1.10.нэг хэлцлээр арилжих бараа, түүхий эдийн доод хэмжээг тогтоох;

5.1.11.стандартын шаардлага хангасан агуулах, тээврийн байгууллага, лабораторит итгэмжлэл олгох.

5.2.Бирж нь биржийн арилжааны зах зээлд оролцогчдын нийтлэг үйл ажиллагааг зохицуулсан дор дурдсан журмыг энэ хуулийн 8.1-д заасан Биржийн зохицуулах зөвлөлөөр хэлэлцүүлэн баталж, мөрдүүлнэ:

5.2.1.бараа, түүхий эдийг бэлтгэх, хаяглах, хадгалах, тээвэрлэх;

5.2.2.бараа, түүхий эдийг бүртгэх;

5.2.3.бараа, түүхий эдийг агуулахад хүлээн авах;

5.2.4.биржээр арилжих гэрээний стандарт тогтоох, мөрдүүлэх;

5.2.5.биржийн арилжааг зохион байгуулах;

5.2.6.биржийн арилжааны үнэ бүрдэлтэд хяналт тавих;

5.2.7.биржийн арилжааны төлбөр тооцоо хийх;

5.2.8.энэ хуулийн 4.3-т заасан мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах;

5.2.9.биржийн арилжаанд оролцогчийн үйл ажиллагааг зохицуулах;

5.2.10.энэ хуулийн 5.1.11-д заасан агуулах, тээврийн байгууллага, лабораторит итгэмжлэл олгох;

5.2.11.биржээр арилжих бараа, түүхий эдийн гарал үүсэл, чанарыг баталгаажуулах;

5.2.12. биржийн дэнчингийн хувь хэмжээг тогтоох;

5.2.13.баталгааны санд биржийн дэнчин байршуулах, үүргийн гүйцэтгэлийг хангуулах;

5.2.14.бусад.

## 6 дугаар зүйл. Биржийн төлбөр тооцоо, хадгаламж

6.1.Бирж нь биржийн гэрээний төлбөрийн үүргийг тодорхойлох, төлбөр тооцоог гүйцэтгэх, гэрээг бүртгэх, хадгалах үйлчилгээг гэрээний үндсэн дээр банк, үнэт цаасны төлбөр тооцооны байгууллагаар гүйцэтгүүлэх, эсхүл уг үүргийг гүйцэтгэх тусгайлсан нэгж /цаашид “төлбөр тооцооны төв” гэх/-тэй байна.

6.2.Энэ хуулийн 6.1-д заасан төлбөр тооцооны төв нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24, 25 дугаар зүйлд зааснаас гадна дараах эрх, үүрэгтэй:

6.2.1.талууд гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн болон хэсэгчлэн биелүүлээгүйгээс гарах хохирлын хэмжээг тодорхойлох;

6.2.2.гэрээгээр хүлээсэн төлбөрийн үүргийг гүйцэтгүүлэх;

6.2.3.энэ хуулийн 6.2.2-т заасан үүргийг гүйцэтгүүлэх зорилгоор төлбөр тооцооны эрсдэлийг зохицуулах;

6.2.4.бусад.

## 7 дугаар зүйл.Биржийн арилжааны төрөл, хэлбэр

7.1.Биржээр зориулалтын байранд, эсхүл цахим сүлжээг ашиглан дуудлага худалдааны хэлбэрээр дараах төрлийн гэрээг арилжина:

7.1.1.шууд арилжих гэрээ /спот/;

7.1.2.хугацаат гэрээ /форвард/ ;

7.1.3.нэг загварын гэрээ /фьючерс/;

7.1.4.ирээдүйд худалдах, худалдан авах гэрээ /опцион/.

7.2.Бараа, түүхий эдийг тогтоосон үнээр шууд, биет байдлаар нийлүүлэх гэрээг “шууд арилжих гэрээ” гэнэ.

7.3.Бараа, түүхий эдийг тогтоосон хугацаанд, тохиролцсон нөхцөлөөр, биет байдлаар ирээдүйд нийлүүлэх болон төлбөр гүйцэтгэх гэрээг “хугацаат гэрээ” гэнэ.

7.4.Бараа, түүхий эдийг тогтоосон хугацаанд, тохиролцсон үнээр ирээдүйд нийлүүлэх стандарт нөхцөл бүхий гэрээг ”нэг загварын гэрээ” гэнэ.

7.5.Иргэний хуулийн 269.1-д заасан гэрээг ”ирээдүйд худалдах, худалдан авах гэрээ” гэнэ.

**8 дугаар зүйл.Биржийн зохицуулах зөвлөл**

8.1.Бирж нь биржийн арилжааны зах зээлд оролцогчдын үйл ажиллагаанд хяналт тавих, тэдгээрийн үйл ажиллагааг уялдуулах зорилготой орон тооны бус биржийн зохицуулах зөвлөл /цаашид “зохицуулах зөвлөл” гэх/-тэй байна.

8.2.Зохицуулах зөвлөл 13 гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн 6 гишүүн нь үнэт цаас, хөдөө аж ахуй, худалдаа, зам, тээвэр, гааль, стандартчилал, чанарын асууд ал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын төлөөллөөс, 7 гишүүн нь биржийн арилжааны зах зээлд оролцогчдыг төлөөлсөн төрийн бус байгууллагын төлөөллөөс тус тус бүрдэнэ.

8.3.Зохицуулах зөвлөлийн гишүүдийг хөдөө аж ахуй, худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын санал болгосноор Засгийн газар томилж, чөлөөлнө.

8.4.Зохицуулах зөвлөлийн дарга нь төрийн захиргааны байгууллагын төлөөлөл байх бөгөөд түүнийг зохицуулах

зөвлөлийн гишүүдийн дотроос гишүүдийн олонхийн саналаар 3 жилийн хугацаагаар сонгоно.

8.5.Зохицуулах зөвлөл нь дараах чиг үүрэгтэй:

8.5.1.энэ хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэл өгөх;

8.5.2.биржийн арилжааны зах зээлд оролцогчийн үйл ажиллагаанд хяналт тавих, тэдгээрийн үйл ажиллагааг уялдуулах;

8.5.3.биржийн үйл ажиллагааны чиглэлээр зөвлөмж, дүгнэлт гаргах.

8.6.Зохицуулах зөвлөлийн дүрэм, үйл ажиллагааны журмыг Засгийн газар батална.

8.7.Зохицуулах зөвлөл үйл ажиллагаагаа Засгийн газарт тайлагнана.

8.8.Зохицуулах зөвлөл нь ажлын албатай байна.

**9 дүгээр зүйл.Биржийн ажилтанд хориглох зүйл**

9.1.Биржийн ажилтанд дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

9.1.1.биржийн арилжаанд оролцох;

9.1.2.биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн компани байгуулах;

9.1.3.биржийн арилжаанд оролцогчийн арилжааны нууцыг агуулсан мэдээ, мэдээллийг хувийн ашиг сонирхолд ашиглах, бусдад задруулах;

9.1.4.биржийн арилжааны зуучлагч /брокер/-тай үгсэн хуйвалдаж биржийн арилжааг шударга бусаар явуулах;

9.1.5.бараа, түүхий эдийн үнэд нөлөөлж болох мэдээллийг

орхигдуулах, нуун дарагдуулах, зохих журмын дагуу мэдээлэл өгөхөөс татгалзах;

9.1.6.ажил, үүргээ гүйцэтгэснийхээ төлөө бусад этгээдээс урамшуулал, мөнгөн шагнал, шан харамж авах.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ
## БИРЖИЙН АРИЛЖААНД ОРОЛЦОГЧ

### 10 дугаар зүйл.Биржийн арилжаанд оролцогч

10.1.Биржийн арилжаанд оролцогчийг байнгын болон байнгын бус гишүүн оролцогч гэж ангилна.

10.2.Биржийн арилжааны зуучлагч /брокер/ нь үндэсний хөрөнгө оруулалт давамгайлсан хуулийн этгээд байх бөгөөд биржийн байнгын гишүүн оролцогч байна.

10.3.Хоршоо нь байнгын бус гишүүн оролцогч байна.

10.4.Биржийн байнгын гишүүн оролцогч биржийн арилжаанд оролцох тусгай зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хорооноос Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20.4 болон энэ хуулийн 11.2.3, 11.2.6-д заасан шаардлагыг хангасан тохиолдолд авна.

10.5.Биржийн арилжаанд дараах этгээдийг оролцохыг хориглоно:

10.5.1.биржийн ажилтан;

10.5.2.даатгал, тусламжийн сан, тэдгээрийн ажилтан;

10.5.3.хууль тогтоомжоор аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхийг хориглосон бусад этгээд.

10.6.Биржийн байнгын бус гишүүн оролцогч биржийн арилжаанд оролцох зөвшөөрлийг биржээс авсан байна.

10.7.Хоршоо нь анхан шатны тордолт хийж стандартын шаардлага хангасан бараа, түүхий эдийг биет байдлаар нийлүүлэх гэрээ байгуулж биржийн арилжаанд оролцоно.

10.8.Гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүн биржийн арилжаанд биржийн байнгын гишүүн оролцогчоор зуучлуулан оролцоно.

**11 дүгээр зүйл.Биржийн арилжаанд оролцогчийн эрх, үүрэг**

11.1.Биржийн арилжаанд оролцогч нь дараах нийтлэг эрх, үүрэгтэй:

11.1.1.биржийн арилжааг ил тод, шударгаар явуулах;

11.1.2.стандартын /бэлтгэх, хадгалах, тээвэрлэх, баглаа боодлын/ дагуу бэлтгэн сумын мал эмнэлэг, үржлийн тасагт бүртгүүлж, мэргэжлийн хяналтын байцаагчийн дүгнэлт гаргуулсан бараа, түүхий эдийг арилжих;

11.1.3.бараа, түүхий эдийн чанар, тоо хэмжээг биржид үнэн зөв мэдээлэх, бүртгүүлэх;

11.1.4.энэ хуулийн 11.1.3-т заасныг зөрчсөнөөс худалдан авагчид учирсан хохирлыг тухайн арилжаанд оролцогч хариуцан барагдуулах;

11.1.5.биржийн арилжааны мэдээллийг ашиглах;

11.1.6.биржийн дүрэмд заасан бусад эрх, үүрэг.

.

11.2.Биржийн байнгын гишүүн оролцогч нь энэ хуулийн 11.1-д зааснаас гадна дараах эрх, үүрэгтэй:

11.2.1.суудлын эрх авах;

11.2.2.энэ хуулийн 7.1.1-7.1.4-т заасан гэрээ байгуулсны үндсэн дээр биржийн арилжаанд тогтмол оролцох;

11.2.3.бараа, түүхий эдийг хүлээн авах, хадгалах, бэлтгэх зориулалтын итгэмжлэгдсэн агуулахтай байх, эсхүл итгэмжлэгдсэн агуулах бүхий этгээдтэй гэрээ байгуулсан

байх;

11.2.4.биржийн арилжааны сүлжээнд холбогдсон байх;

11.2.5.эрх бүхий байгууллагаас зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байх;

11.2.6.итгэмжлэгдсэн лаборатори, тээврийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулсан байх.

**12 дугаар зүйл.Биржийн арилжаанд оролцогчид хориглох зүйл**

12.1.Биржийн арилжаанд оролцогчид дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

12.1.1.биржийн арилжаанд оролцогч бусад этгээдийн болон түүний бараа, түүхий эдийн нэр хүндийг гутаах, эсхүл өрсөлдөгчөө алдагдалд оруулж болохуйц худал, зөрүүтэй буюу гуйвуулсан мэдээ тараах;

12.1.2.харилцан тохиролцох замаар биржээр арилжих бараа, түүхий эдийн үнийн түвшинд хязгаар тогтоох;

12.1.3.өөрийн болон биржийн арилжаанд оролцогч бусад этгээдийн бараа, түүхий эдийг үйлдвэрлэсэн арга, хэрэглээний шинж чанарын гол үзүүлэлт, хэрэглэх аргын талаар худал, зөрүүтэй мэдээлэх, эсхүл үнэн байдлыг гуйвуулах зэргээр бусдыг төөрөгдүүлэх, хуурч мэхлэх;

12.1.4.хууль тогтоомжоор хориглосон бусад үйл ажиллагаа.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
## БИРЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТ

**13 дугаар зүйл.Аудит**

13.1.Биржийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд Үндэсний аудитын газар жил бүр аудит хийж дүгнэлт гаргана.

13.2.Үндэсний аудитын газар энэ хуулийн 13.1-д заасан дүгнэлтээ Засгийн газарт танилцуулна.

**14 дүгээр зүйл.Биржийн тайланг нийтэд мэдээлэх**

14.1.Биржийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ.

## ТАВДУГААР БҮЛЭГ
## БУСАД ЗҮЙЛ

**15 дугаар зүйл.Биржийн үйл ажиллагаатай холбогдсон маргааныг шийдвэрлэх**

15.1.Биржийн гэрээ байгуулах, түүнээс үүсэх эрх, үүрэгтэй холбогдон гарсан маргааныг эрх бүхий байгууллага хянан хэлэлцэж шийдвэрлэх бөгөөд уг шийдвэрийг эс зөвшөөрвөл талууд шүүхэд гомдол гаргаж болно.

15.2.Биржтэй холбогдсон маргаантай асуудлыг арбитраар шийдвэрлүүлж болно.

**16 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

16.1.Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол эрх бүхий улсын байцаагч зөрчлийн шинж байдлыг харгалзан дараах хариуцлага хүлээлгэнэ:

16.1.1.энэ хуулийн 4.8-д заасныг зөрчиж биржийн нэр ашиглан бараа, түүхий эдийг худалдсан иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгож, хууль бусаар олсон орлогыг хураах;

16.1.2.энэ хуулийн 12.1-д заасныг зөрчсөн биржийн байнгын

бус гишүүн оролцогчийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, байнгын гишүүн оролцогчийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, хууль бусаар олсон орлогыг хураах, энэ зөрчлийг давтан гаргавал бирж дээр үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг хүчингүй болгох;

16.1.3.энэ хуулийн 9.1-д заасныг зөрчсөн биржийн ажилтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, үгсэн хуйвалдаж биржийн арилжаанд оролцсон оролцогчийн зөвшөөрлийг цуцлах, хууль бусаар олсон орлогыг хураах;

16.1.4.бараа, түүхий эдийн чанар, тоо хэмжээг үнэн зөв мэдээлж, бүртгүүлээгүйгээс биржийн арилжаанд оролцогчид учирсан хохирлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлэх, үгсэн хуйвалдсан арилжаанд оролцогчийн зөвшөөрлийг цуцлах, хууль бусаар олсон орлогыг хураах.

**17 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

17.1.Энэ хуулийг 2012 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН**
**ТОГТООЛ**

2011 оны 06 сарын 02 өдөр Дугаар 29 Төрийн ордон, Улаанбаатар хот

## Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6-д заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /С.Батболд/-т даалгасугай:

1/Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль батлагдсантай холбогдуулан Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай, Хоршооны тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулж 2012 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

2/хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн бирж байгуулах, тус биржээр арилжих бараа, түүхий эдийн жагсаалт, бараа, түүхий эдийг коджуулах журмыг батлах;

3/хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн арилжаанд оролцох биржийн арилжааны зуучлагч /брокер/, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдээс бүрдсэн хоршооны загвар бий болгох;

4/хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн арилжаанд оролцогчдыг сургаж бэлтгэх, тус биржээр арилжих бараа, түүхий эдийн чанар, стандартын хэрэгжилтийг хангуулах сургалт зохион байгуулах, хууль сурталчлах үүрэг бүхий нэгжийг байгуулан Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль хүчин төгөлдөр мөрдөж эхлэх хүртэлх хугацаанд ажиллуулах;

5/хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийг хүлээн авч анхан шатны тордолт хийх байр, талбай, хадгалах агуулах, тээврийн судалгаа гаргаж, бэлэн байдлыг хангах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

6/энэ тогтоолд заасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг улсын төсөвт тусган санхүүжүүлэх.

2.Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн үйл ажиллагаанд хяналт тавих журам боловсруулж батлахыг Санхүүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/-нд даалгасугай.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо /П.Алтангэрэл/-нд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ**

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 2011 оны 7 дугаар сарын 20-ны өдөр | Дугаар 235 | Улаанбаатар хот |

## ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАРАЛТАЙ БАРАА,ТҮҮХИЙ ЭДИЙН БИРЖ БАЙГУУЛАХ БЭЛТГЭЛ ХАНГАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

“Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2011 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн 29 дүгээр тогтоолыг үндэслэн Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн бирж байгуулах бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2. Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн бирж байгуулах бэлтгэл хангах, сургалт зохион байгуулах, хууль сурталчлах чиг үүрэг бүхий нэгжийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын дэргэд байгуулж, орон тооны дээд хязгаарыг 7 байхаар тогтоосугай.

3. Энэ тогтоолын 2 дугаар зүйлд заасан нэгжийн 2011 оны үйл ажиллагаанд шаардагдах зардлыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багцаас, 2012 оноос эхлэн холбогдох зардлыг төсөвт тусган санхүүжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунайд даалгасугай.

4. Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн бирж байгуулах бэлтгэл ажилд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэхийг Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайханд зөвлөсүгэй.

5. Энэхүү тогтоолын хэрэгжилтийн явц, дүнг улирал бүр Засгийн газарт танилцуулж байхыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунайд даалгасугай.

**Монгол Улсын Ерөнхий сайд С.БАТБОЛД**

**Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.БАДАМЖУНАЙ**

Засгийн газрын 2011 оны 235 дугаар
тогтоолын хавсралт

# ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАРАЛТАЙ БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН БИРЖ БАЙГУУЛАХ БЭЛТГЭЛ ХАНГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хугацаа | Хариуцах яам, агентлаг |
|---|---|---|---|
| 1 | Дараахь хуулийн төсөл боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх:<br>- Хоршооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай<br>- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай<br>- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай<br>- Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай<br>- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай<br>- Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 2011 оны IV улирал | СЯ, ХХААХҮЯ, ХЗДХЯ, Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ) |
| 2 | Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах | 2011 оны III, IV улирал | ХХААХҮЯ |
| 3 | Бололцоотой аймаг, сумдыг шилэн кабелийн сүлжээнд холбож, биржийн цахим арилжаа явуулах нөхцөлийг төв, орон нутагт бий болгох | 2011-2012 он | МШХХТГ |

| | | | |
|---|---|---|---|
| 4 | Биржийн программ хангамжийг шинээр боловсруулах, эсхүл гадаадын биржийн программ хангамжийг хэрэглэх ажлыг судлан шийдвэрлэх | 2011-2012 он | ХХААХҮЯ, МШХХТГ |
| 5 | Биржийн дүрэм, хяналт тавих журмын төслийг боловсруулж батлах | 2012 оны II улирал | ХХААХҮЯ, СЗХ |
| 6 | Биржийн арилжаанд оролцогчдын үйл ажиллагааг зохицуулах чиглэлээр дараахь баримт бичгийн төслийг боловсруулж батлах:<br>-Арилжааны журам<br>-Төлбөр, тооцооны журам<br>-Барааг хадгалах, тээвэрлэх журам<br>-Бараа, түүхий эдийг коджуулах журам<br>-Биржээр арилжих бараа, түүхий эдийн жагсаалт<br>-Бусад | 2011-2012 он | ХХААХҮЯ, СЯ, ЗТБХБЯ, СЗХ, МХЕГ, ГЕГ, СХЗГ, холбогдох мэргэжлийн холбоод |
| 7 | Биржийн чиглэлээр гадаад, дотоодын их дээд сургуульд суралцаж төгссөн болон суралцаж байгаа монгол иргэдийн судалгааг гаргаж, бирж байгуулахад шаардлагатай хүний нөөцийг бүрдүүлэх арга хэмжээ авах | 2011-2012 он | ГХЯ, БСШУЯ, ХХААХҮЯ |
| 8 | Биржийн удирдлагын баг, зарим мэргэжлийн хүнийг гадаадад сургах, гадаадын адил төстэй биржид дадлага хийлгэх | 2011-2012 он | ХХААХҮЯ, ГХЯ, БСШУЯ, СЗХ Хувийн хэвшил |
| 9 | “Биржийн менежмент, худалдаа” хичээлийн хөтөлбөр боловсруулж, холбогдох их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрт тусгах | 2011 оны 9 дүгээр сарын 1-нээс | БСШУЯ, ХХААХҮЯ, СЗХ |
| 10 | Биржийн арилжаанд оролцогч (брокер, хоршоо)-дыг сургах сургагч багш нарыг бэлтгэх, биржийн хяналт, зохицуулалт хариуцсан ажилтнуудыг сургаж бэлтгэх | 2011-2012 он | ХХААХҮЯ, СЗХ |

| | | | |
|---|---|---|---|
| 11 | Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийг сургах сургагч малчин-багш бэлтгэх | 2011-2012 он | ХХААХҮЯ, МШХХТГ, мэргэжлийн холбоод |
| 12 | Бараа, түүхий эдийн болон агуулах, тээврийн стандартыг хянаж шаардлагатай бол зарим стандартыг шинэчлэх, олон улсын стандартыг нутагшуулах | 2011 оны III, IV улирал | СХЗГ, ХХААХҮЯ, МХЕГ |
| 13 | Бараа, түүхий эдийг хүлээн авч анхан шатны тордолт хийх байр, талбай, хадгалах агуулах, болон тээврийн хэрэгсэл, лабораторийн судалгаа гаргаж, тэдгээрийн чадавхийг бэхжүүлэх чиглэлээр авах арга хэмжээг тодорхойлон хэрэгжүүлж бэлэн байдлыг хангах | 2011-2012 он | ХХААХҮЯ, ЗТБХБЯ, Авто тээврийн газар, СХЗГ, МХЕГ, аймаг, сумын Засаг дарга |
| 14 | Биржийн арилжаанд оролцох биржийн арилжааны зуучлагч (брокер), хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдээс бүрдсэн загвар хоршоог сумдад байгуулж чадавхижуулах, загвар хоршооны туршлагыг улсын хэмжээнд дэлгэрүүлэн сурталчлах | 2011-2012 он | ХХААХҮЯ, аймаг, сумын Засаг дарга |
| 15 | Аймгийн хүнс, хөдөө аж ахуй, жижиг, дунд үйлдвэрийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Стандартчилал, хэмжил зүйн хэлтэс болон сумдын Засаг даргын Тамгын газрын мал эмнэлэг, үржлийн тасгийг бэхжүүлэх, тэдгээрт ажиллагсдыг сургах, мэргэшүүлэх | 2011-2012 он | ХХААХҮЯ, МХЕГ, СХЗГ, аймаг, сумын Засаг дарга |
| 16 | Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль, биржийн ач холбогдлыг олон нийтэд сурталчлах | 2011-2012 он | МҮОНРТ, аймаг, сумын Засаг дарга |

-------oOo------

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,**
**ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН**

# ТУШААЛ

2011 оны 08 сарын 25 өдөр Дугаар А/147 Улаанбаатар хот

## Төслийн нэгж байгуулах тухай

“Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн бирж байгуулах бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2011 оны 235 дугаар тогтоолыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн бирж байгуулах бэлтгэл хангах” чиг үүрэг бүхий төслийн нэгжийн орон тоог 1 дүгээр хавсралтын ёсоор 7 хүний бүрэлдэхүүнтэй баталсугай.
2. Нэгжийн 2011 оны үйл ажиллагаанд шаардагдах зардлыг 2 дугаар хавсралтын ёсоор баталж, яамны төвлөрсөн арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Төрийн нарийн бичгийн дарга Т. Гантулгад зөвшөөрсүгэй.
3. Нэгжийг удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Хүнсний үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Ч. Энх-Амгалан)-т даалгасугай.
4. “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн бирж байгуулах бэлтгэл хангах” чиглэлээр нэгжтэй хамтран ажиллахыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуй, жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга нарт үүрэг болгосугай.

**САЙД Т. БАДАМЖУНАЙ**

## 100 АСУУЛТ, ХАРИУЛТ

## ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАРАЛТАЙ БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН БИРЖИЙН ТАЛААР

### 1. Монголд бирж байгуулах үндсэн шалтгаан юу вэ?

Манай орон жилдээ хөдөө аж ахуйн гол нэрийн 1.1 тэрбум орчим ам долларын түүхий эд бэлтгэдэг. Гэвч түүхий эд бэлтгэлийн тогтолцоо бүрдэж хөгжөөгүйгээс түүхий эдийн нөөцөө бүрэн ашиглаж чаддаггүй. Малчид, үйлдвэрлэгчдийн харилцаа алдагдан, түүхий эдийн дамын худалдаа газар авч, үйлдвэрлэгчид түүхий эдээр дутагдах, малчдын орлого тогтворгүйтэх, тэдний нийгмийн баталгаа алдагдах, түүхий эдийн чанар муудах, үнэгүйдэх зэрэг олон сөрөг үр дагавар үүсч байна. Түүхий эд бэлтгэлийн тогтолцоог боловсронгуй болгох оновчтой арга нь бирж байгуулах юм.

### 2. Бирж анх, хаана, хэзээ үүссэн бэ?

Дэлхийн анхны бирж нь 19-р зууны эхээр АНУ-д хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэгч, худалдаачдын сайн дурын үндсэн дээр үүсэн байгуулагдаж байжээ. Орчин үеийн биржийн эхлэл нь 1848 онд АНУ-д байгуулагдсан “Чикагогийн худалдааны бирж” юм.

### 3. Чикагогийн бирж тухайн үед яагаад байгуулагдаж байсан бэ?

Чикагогийн бирж дор дурьдсан нөхцөл байдлын улмаас байгуулагдаж байжээ.Үүнд:

* Тариаланчид худалдан авагч олж чадаагүйгээс шалтгаалан борлогдоогүй үлдсэн үр тариагаа Чикаго хотын дэргэдэх Мичиган нууранд их хэмжээгээр асгаж байсан;

* Худалдан авагч хайх, худалдаа хийх, нийлүүлэх үйл ажиллагааны зардал өндөр тул зарим үед үр тариагаа удаан хугацаагаар хадгалах шаардлага тулгарч, үр тарианы чанар нь алдагдаж байсан;

* Бараа, түүхий эдийн тодорхой стандартгүй, зах зээл нь

зохион байгуулалтгүй байсан;

* Худалдан авагчид эргэлтийн хөрөнгө, санхүүжилт олоход бэрхшээлтэй байсан.

**4. Биржийн үндсэн чиг үүрэг нь юу вэ?**

Биржийн үндсэн чиг үүрэг нь зах зээлийн мэдээллийг ил тод болгох, бодит үнэ тогтох нөхцөлийг бүрдүүлэх, бизнесийн үйл ажиллагааны нийт зардлыг бууруулах явдал юм.

**5. Биржийн хэдэн төрөл байдаг вэ?**

Олон улсад дараах төрлийн бирж байдаг:

* Хөрөнгийн бирж;

* Бараа, түүхий эдийн бирж;

* Валютын бирж г.м.

**6. Бараа, түүхий эдийн биржээр ихэвчлэн ямар төрлийн бараа арилжаалагддаг вэ?**

Олон улсад биржээр дараах төрлийн бараа голчлон арилжаалагддаг байна:

* Уул уурхайн бараа /алт, зэс, цайр г.м/

* Түлш эрчим хүчний бараа /нефть, нүүрс г.м/

* Хөдөө аж ахуйн бараа, түүхий эд /улаан буудай, элсэн чихэр, цагаан будаа, амьд мал г.м/

Хөдөө аж ахуйн бараа, түүхий эдийн бирж нь бүтээгдэхүүний нэр төрөл, гэрээний тоо, оролцогчдын цар хүрээгээрээ томоохон байр суурийг эзэлдэг байна.

**7. Бирж байгуулахын ач холбогдол нь юу вэ?**

Бирж нь дараах ач холбогдолтой.Үүнд:

* Зах зээлд нэвтрэх боломжийг нэмэгдүүлэх;

* Өрсөлдөөнийг бий болгох;

* Бараа, түүхий эдийн чанарыг сайжруулах;

* Гэрээний тэгш байдлыг хангах;

* Үйл ажиллагааны зардлыг бууруулах;

* Оролцогчдын үүрэг хариуцлагыг өндөржүүлэх;

* Үнийн ил тод байдлыг хангах;

* Сав баглаа боодлыг сайжруулах.

**8. Бирж байгуулахад анхаарах гол асуудал юу байдаг вэ?**

Хөгжиж байгаа орнуудад биржийг шинээр үүсгэн байгуулахдаа амжилттай ажиллаж байгаа аль нэг орны биржийн үйл ажиллагааг шууд хуулбарлалгүй, харин өөрийн орны онцлог нөхцөлийг харгалзан, уялдуулдаг байна.

**9. Биржийн хөгжлийг хэрхэн авч үздэг вэ?**

Бирж нь хөгжлийн явцад дараах түвшинд үйл ажиллагаагаа явуулдаг:

* Орон нутгийн /local/;

* Бүс нутгийн /regional/;

* Олон улсын /international/.

**10. Биржийн хөгжлөөр ямар биржүүд тэргүүлж байна вэ?**

АНУ болон Европын биржүүд хөгжлөөрөө дэлхийд тэргүүлж байна.

**11. Хөдөө аж ахуйн бараа, түүхий эдийн арилжааны томоохон ямар биржүүд байдаг вэ?**

* АНУ-ын Чикагогийн худалдааны бирж;

* АНУ-ын Нью-Иоркийн худалдааны бирж;

* Японы Токиогийн үр тарианы бирж;

* БНХАУ-ын Шанхайн фьючерсийн худалдааны бирж;

* БНХАУ-ын Далианы бирж г.м.

**12. Биржийн хөгжлийн шинэ эрин үе хэзээ эхэлсэн бэ?**

Дэлхийн биржийн хөгжлийн түүхэнд 1990 оноос шинэ эрин үе эхэлсэн. Өөрөөр хэлбэл, зүүн Европ, хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан болон Ази, өмнөд Америкийн улс орнуудад бараа түүхий эдийн биржүүд шинээр байгуулагдаж эхэлсэн.

**13. Биржийн хөгжлийн чиг хандлага ямар байна вэ?**

Дэлхийн эдийн засгийн өсөлттэй уялдан биржийн хөгжил улам эрчимжиж, Ази, Латин Америкийн зарим улс орнуудын эзлэх байр суурь улам нэмэгдэх хандлагатай байна. Тэд АНУ, Европын томоохон биржүүдтэй хамтран ажиллах хэлбэрээр үйл ажиллагаагаа өргөжүүлж байгаа юм.

**14. Биржийг улс орнууд хэрхэн үүсгэн байгуулдаг вэ?**

Олон улсын туршлагаас үзэхэд барааны бирж байгуулах ажил нь цаг хугацаа, зардал их шаарддаг тул тухайн орны Засгийн газраас ихэвчлэн үүсгэн байгуулж, үйл ажиллагаа нь жигдэрч, чадвартай болсных нь дараа хувийн хэвшилд шилжүүлдэг байна.

**15. Өнөөгийн байдлаар ямар улс орнууд бирж байгуулаагүй вэ?**

Эдийн засгийн хөгжлөөр сул Ази, Африкийн зарим орнуудад бирж байгуулаагүй, байгуулах талаар ямар нэг оролдлого хийгээгүй байна.

**16. Барааны бирж санхүүжилтээ хэрхэн шийдвэрлэдэг вэ?**

Бирж нь хөгжлийн эхний шатанд Засгийн газраас, харин үйл ажиллагаа нь тогтворжсоны дараа арилжаанд оролцох суудлын эрх, арилжааны шимтгэл болон биржийн бусад үйлчилгээг үзүүлсэн төлбөр, хураамжаас санхүүждэг.

**17. Монгол Улсад барааны бирж байсан уу?**

Манай улсад 1990-1992 онд Эрдэнэт бирж, Хөдөө аж ахуйн бирж гэж байгуулагдаж байсан боловч хэлбэр, агуулгын хувьд биржийн жинхэнэ ойлголтын хэмжээнд хүрээгүй, тухайн үед зах зээлийн тогтолцоо төлөвшөөгүй, санхүү эдийн засгийн хямралтай, төрийн дорвитой дэмжлэг байгаагүйгээс амжилттай

ажиллаж чадаагүй.

**18. Монгол Улсад барааны бирж байгуулж, цахим арилжаа явуулах үндсэн нөхцөл бий юу?**

2010 оны байдлаар манай улсын 329 сумын 160 нь интернетийн шилэн кабелийн сүлжээнд холбогдсон, 2012 онд 272 сум холбогдох урьдчилсан тооцоотой, 309 сум, багууд үүрэн телефоны сүлжээнд холбогдсон, түүнчлэн бүх сумдад арилжааны аль нэг банкны салбар, тооцооны төв ажиллаж байгаа зэрэг нь бирж байгуулж, цахим арилжаа явуулах, төлбөр тооцоог гүйцэтгэх боломжтойг харуулж байна.

**19. Бирж байгуулагдсанаар малчин хүнд ямар ач холбогдолтой вэ?**

Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль хэрэгжиж, бирж байгуулагдан үр дүнтэй ажилласнаар малчдад дараах ач холбогдолтой. Үүнд:

* Бараа, түүхий эдийн үнэ, зах зээлийн талаарх ил тод, бодитой мэдээллээр шуурхай, тасралтгүй, найдвартай хангагдана;

* Түүхий эдээ зарж борлуулах талаар санаа зовохгүй, зөвхөн хоршоондоо нийлүүлж, арилжааны үр ашгаас хүртэнэ;

* Түүхий эдийн үнийн хэт хэлбэлзлээс хамгаалагдана;

* Орлого тогтворжиж, нийгмийн баталгаа хангагдана;

* Түүхий эдийн чанар сайжирна;

* Хамтын хөдөлмөр эрхлэхийн давуу талыг амьдрал ахуйдаа ашиглах боломж бүрдэнэ;

* Мал аж ахуйгаа төлөвлөх, мал аж ахуйн эрсдэлийг урьдчилан харах, сэргийлэх боломжтой болно.

**20. Бирж байгуулагдсанаар хоршоонд ямар ач холбогдолтой вэ?**

Хөдөө аж ахуйн гаралтай бараа түүхий эдийн биржийн тухай

хууль хэрэгжиж, бирж байгуулагдан үр дүнтэй ажилласнаар хоршоонд дараах ач холбогдолтой. Үүнд:

* Түүхий эдийн зах зээл, үнийн ил тод, бодитой мэдээллээр тасралтгүй, найдвартай хангагдана;

* Зах зээлд нэвтрэх боломж нэмэгдэнэ;

* Түүхий эд бэлтгэх, хадгалах, зах зээл хайх, тээвэрлэх нийт зардал хэмнэгдэнэ;

* Гишүүдээсээ түүхий эдээ төвлөрүүлэн зохион байгуулж, ангилан ялгалт, тордолт хийж зах зээлд нийлүүлснээр арилжаанаас хүртэх үр ашиг нэмэгдэнэ.

**21. Бирж байгуулагдсанаар үндэсний үйлдвэрүүдэд ямар ач холбогдолтой вэ?**

Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль хэрэгжиж, бирж байгуулагдан үр дүнтэй ажилласнаар үндэсний үйлдвэрүүдэд дараах ач холбогдолтой. Үүнд:

* Түүхий эдийн зах зээл, үнийн ил тод, бодитой мэдээллээр тасралтгүй, найдвартай хангагдана;

* Үйлдвэрлэлийн хүчин чадлаа бүрэн ашиглах боломж бүрдэнэ;

* Чанартай түүхий эдээр хангагдана;

* Түүхий эдээ орон нутгаас цуглуулах, бэлтгэх нийт зардал буурна.

**22. Бирж байгуулагдсанаар улсад ямар ач холбогдолтой вэ?**

Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль хэрэгжиж, бирж байгуулагдан үр дүнтэй ажилласнаар улсад дараах ач холбогдолтой. Үүнд:

* Түүхий эдийн дам худалдааг цэгцэлж, далд эдийн засгийг багасгана;

* Малчдын нийгмийн баталгааг хангана;

* Үндэсний үйлдвэрүүд хүчин чадлаа бүрэн ашиглаж, бүтээгдэхүүнээ экспортлох нөхцөл бүрдсэнээр улсын төсвийн орлого нэмэгдэнэ;

* Гадаад улсын түүхий эдийн бааз болох аюулаас сэргийлнэ.

**23. Бирж байгуулагдсанаар орон нутагт ямар ач холбогдолтой вэ?**

Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль хэрэгжиж, бирж байгуулагдан үр дүнтэй ажилласнаар орон нутагт дараах ач холбогдолтой. Үүнд:

* Орон нутгийн дэд бүтэц сайжирна;

* Орон нутагт шинээр ажлын байрууд бий болно;

* Орон нутгийн иргэдийн амьдралын идэвхи нэмэгдэж, нөхцөл сайжирна.

* Орон нутгийн төсөвт орох татварын хэмжээ нэмэгдэнэ.

**24. Бирж байгуулагдсанаар банк, санхүүгийн зах зээлд ямар өөрчлөлт гарах вэ?**

Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль хэрэгжиж, бирж байгуулагдан үр дүнтэй ажилласнаар бэлэн мөнгөөр хийгддэг байсан түүхий эдийн худалдаа бэлэн бусаар хийгдэх нөхцөл бүрдэж, санхүүгийн зах зээлд шинэ үйлчилгээнүүд бий болно.

**25. Малчин хүн бараа, түүхий эдээ биржээр хэрхэн арилжаалах вэ?**

Малчид биржээр дамжуулан бараа, түүхий эдээ худалдахын тулд хоршоонд нэгдэх хэрэгтэй. Биржийн арилжаанд “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай” хуульд заасан шаардлагыг хангасан хоршоо, брокер оролцох боломжтой.

**26. Хоршоо шинээр байгуулах, хоршоонд гишүүнээр элсэх зэрэг хоршооны бүхий л асуудлаар мэргэжил арга зүйн**

**зөвлөлгөөг хаанаас шуурхай авч болох вэ?**

Монгол Улсын Засгийн газраас “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хүрээнд сумдын Засаг даргын Тамгын газрын бүтцэд Мал эмнэлэг, үржлийн тасгийг байгуулсан. Энэ тасгийн мэргэжилтнүүдээс хоршооны талаар зөвлөлгөө авч болно.

**27. “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай” хуулийн хүрээнд хоршоодын талаар ямар чиглэл баримталж байгаа вэ?**

“Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай” хуулийн хүрээнд гишүүнчлэлийн хүрээ өргөнтэй, гишүүдийнхээ бэлтгэсэн түүхий эдийг төвлөрүүлж, анхан шатны ангилан ялгалт, тордолт хийх, зах зээлд хүргэх чадвартай хоршоодыг бий болгох чиглэл баримталж байна.

**28. Хөдөө аж ахуйн хоршоо ямар чиглэлээр үйл ажиллагаа явуулах боломжтой вэ?**

Хөдөө аж ахуйн хоршоо нь бизнесийн бусад салбараас харьцангуй эрсдэл багатай бөгөөд эргэлт түргэнтэй түүхий эдийн худалдааны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх нь зохистой. Түүхий эдийн худалдаанаас олсон хуримтлалаа дор дурьдсан чиглэлүүдээр хөрөнгө оруулж, гишүүдийнхээ эрх ашгийг бүрэн илэрхийлэх боломж бүрдүүлнэ. Үүнд:

* Түүхий эдийн боловсруулалт;
* Хадлан бэлтгэл, тэжээл үйлдвэрлэл;
* Мал эмнэлэг, үржлийн үйлчилгээ;
* Газар тариалан;
* Хадгаламж, зээлийн үйлчилгээ г.м

**29. Биржээр эхний ээлжинд ямар бараа арилжаалах боломжтой вэ?**

Урьдчилсан судалгаагаар эхний ээлжинд ямааны ноолуур, хонины ноос, улаан буудай, амьд малыг биржээр арилжаалах боломжтой гэж үзэж байна.

**30. Бирж дээр 1 мал, 1 кг ноолуурыг зарж, худалдан авч болох уу?**

Биржээр их хэмжээний барааг багцалж арилжаална.

**31. Биржээр арилжаалах барааг хаана, яаж хадгалах шаардлагатай вэ?**

Биржээр арилжаалах барааг Биржээс итгэмжлэгдсэн агуулахад стандартын шаардлагад нийцүүлэн хадгална.

**32. Биржээр арилжаалах бараа, түүхий эдийн гарал үүсэл, чанарыг ямар байгууллага гэрчлэх вэ?**

Биржээр арилжаалах бараа, түүхий эдийг чанар, стандартын дагуу бэлтгэсэн эсэхийг сумын Мал эмнэлэг, үржлийн тасагт бүртгэж, мэргэжлийн хяналтын байцаагчийн дүгнэлт гаргана.

**33. Үндэсний үйлдвэрүүд түүхий эдээ бирж дээр хэрхэн худалдан авах вэ?**

Үндэсний үйлдвэрүүд брокерт хандан биржээр дамжуулж чанар, стандартын шаардлагад нийцсэн түүхий эдээ худалдан авах боломжтой.

**34. Биржээр арилжаалах барааг яаж тээвэрлэх вэ?**

Биржээр арилжаалах барааг Биржээс итгэмжлэгдсэн тээврийн байгууллагаар тээвэрлэнэ. Биржийн үйл ажиллагаатай зэрэгцэн орон нутагт ачаа тээврийн үйлчилгээ хөгжих нөхцөл бүрдэнэ.

**35. Бирж байгуулагдан ажилласнаар өнөөгийн ченж иргэд ажилгүй болох уу?**

“Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай” хууль хэрэгжиж, бирж байгуулагдан ажилласнаар өнөөгийн ченж иргэдэд сөргөөр нөлөөлөхгүй. Тэд биржийн брокер болж, албан ёсны, цэгцтэй худалдаа эрхлэх боломжтой болно. Нөгөө талаас бэлэн мөнгөөр хийгдэж байгаа түүхий эдийн худалдаа биржээр дамжин, төлбөр тооцоо нь бэлэн бусаар хийгдэж, бэлэн мөнгөнөөс үүдэн гардаг гэмт хэрэг буурах нөхцөл бүрдэнэ.

**36. Биржийн боловсон хүчнийг хэрхэн бүрдүүлэх вэ?**

Биржийн хүний нөөцийг бүрдүүлэх, хөгжүүлэх чиглэлээр шат дараатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Тухайлбал: гадаадын улсуудад биржийн чиглэлээр суралцаж байгаа, суралцсан, ажиллаж байгаа монгол иргэдийн судалгааг гаргаж, хөдөө аж ахуйн бирж байгуулах ажилд татан оролцуулах, “Биржийн менежмент” хичээлийн хөтөлбөрийг боловсруулж, эдийн засгийн чиглэлийн их дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрт тусгах, сургагч багш нарыг бэлтгэх, орон нутагт сургалт өргөнөөр зохион байгуулах г.м.

**37. “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн бэлтгэл ажлыг хэрхэн зохион байгуулах вэ?**

Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн бэлтгэл ажлыг хангах үндсэн чиг үүрэг бүхий төслийн нэгжийг 7 хүний бүрэлдэхүүнтэй зохион байгуулж, шуурхай удирдлагаар хангаж ажиллана.

**38. “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн бэлтгэл ажлын явцад эрх зүйн хүрээнд ямар зохицуулалт хийх шаардлагатай байгаа вэ?**

“Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай” хуулийг хэрэгжүүлэх, бирж байгуулагдан үр дүнтэй ажиллах эрх зүйн орчин, нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор дор дурьдсан хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулна. Үүнд:

* Хоршооны тухай;
* Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай;
* Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай;
* Засгийн газрын тусгай сангийн тухай;
* Үнэт цаасны зах зээлийн тухай;
* Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай.

**39. Биржээр арилжаалах бараа, түүхий эдийн стандартын чиглэлээр ямар ажлууд хийгдэх вэ?**

Түүхий эдийн болон агуулахын стандартад шүүлт хийх, дахин хянах, шаардлагатай стандартыг шинэчлэх, шинээр боловсруулах, стандартын хэрэгжилтийг хангуулах ажлыг нэн тэргүүнд хийхээр төлөвлөж байна.

**40. Биржийн арилжаанд оролцогчид ашиг сонирхлоо хэрхэн илэрхийлэх боломжтой вэ?**

Биржийн арилжаанд оролцогчид төрийн бус байгууллага байгуулах, төлөөллөө Биржийн зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүнд оруулж ажиллуулах замаар эрх ашгаа илэрхийлэх боломжтой. Зохицуулах зөвлөлийн 7 гишүүн нь төрийн бус байгууллагын төлөөлөл байна.

**41. Биржийн хуулийг гаргасан үндэслэл нь үю вэ?**

Түүхий эд бэлтгэлийн тогтолцоог боловсронгуй болгох зорилгоор Засгийн газраас 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөртөө “Хөдөөгийн иргэд бэлтгэсэн түүхий эд, бүтээгдэхүүнээ хэрэглэгчдэд шууд худалдаалах боломж бүрдүүлсэн мэдээллийн технологид суурилсан биржийн сүлжээ байгуулна” гэж заасан.

**42. Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн бирж байгуулах нь салбарын ямар бодлоготой уялдаж байгаа вэ?**

Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн бирж байгуулах нь хөдөө аж ахуйн салбарт хэрэгжиж байгаа дор дурьдсан томоохон хөтөлбөрүүдтэй уялдаж байна. Үүнд:

* “Монгол мал” үндэсний хөтөлбөр;
* “Хүнсний аюулгүй байдал” үндэсний хөтөлбөр;
* “Монгол Улсыг үйлдвэржүүлэх” хөтөлбөр.

**43. “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай” хуулийн зорилт?**

Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийг үүсгэн байгуулах, түүний зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн

үндсийг тогтоох, хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийг бэлтгэн нийлүүлэх, хадгалах, тээвэрлэх, биржээр арилжихтай холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

**44. "Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай" хууль хэзээнээс мөрдөгдөж эхлэх вэ?**

"Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай" хууль 2012 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс мөрдөгдөж эхэлнэ.

**45. "Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай" хуулийн онцлог нь юу вэ?**

"Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай" хууль нь ерөнхий шинжтэй бөгөөд биржийн харилцааг холбогдох дүрэм, журмуудаар зохицуулахаар тусгасан. Биржийн арилжаа нь худалдааны орчин үеийн онцгой арга хэлбэр тул түргэн хөгжлийн явцад гарах өөрчлөлтийг хуулийн хүрээнд дүрэм, журмаар зохицуулах боломжтой.

**46. Хөдөө аж ахуйн гаралтай бараа түүхий эдийн бирж гэж ямар байгууллага байх вэ?**

Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн арилжааг тогтсон журмын дагуу зориулалтын байранд, эсхүл цахим сүлжээгээр хуульд заасан биржийн арилжааны төрөл, хэлбэрээр зохион байгуулдаг компани байна.

**47. Монгол Улсын хэмжээнд хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн арилжааг зохион байгуулах хэдэн бирж үйл ажиллагаа явуулах вэ?**

Монгол Улсын хэмжээнд хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн арилжааг зохион байгуулах төрөлжсөн 1 бирж үйл ажиллагаа явуулна.

**48. Бирж нь биржийн арилжааг зохион байгуулахдаа ямар үндсэн зарчмыг баримтлах вэ?**

Бирж нь арилжааг зохион байгуулахдаа бие даасан, нээлттэй,

ил тод, хараат бус байх үндсэн зарчмыг баримтална.

**49. Бирж нь ямар нөхцөл шаардлагыг хангасан байх ёстой вэ?**

Бирж нь зориулалтын байр, төвлөрсөн мэдээллийн сантай байх бөгөөд арилжааг зохион байгуулах программ хангамж, сүлжээний найдвартай байдлыг хангасан байна.

**50. Биржээр ямар бараа түүхий эдийг арилжих вэ?**

Хөдөө аж ахуй, худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан биржээр арилжих барааны жагсаалтад орсон, гарал үүсэл, чанарын гэрчилгээтэй, биржийн гэрээний стандартыг хангасан бараа, түүхий эдийг арилжина.

**51. Биржийн арилжаанд оролцогчид хэн байх вэ?**

Биржид бараа, түүхий эд арилжих зорилгоор бүртгүүлсэн, биржийн арилжаанд оролцох зөвшөөрөлтэй хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл эрхлэгчдээс бүрдсэн хоршоо, биржийн арилжааны зуучлагч /брокер/ биржийн арилжаанд оролцоно.

**52. Биржийн арилжааны зах зээлд оролцогч гэж хэн байх вэ?**

Бараа, түүхий эдийг бэлтгэх, үйлдвэрлэх, чанар, тоо хэмжээг тодорхойлох, хадгалах, тээвэрлэх, зуучлан арилжих, биржийн арилжааг зохион байгуулах, төлбөр тооцоог гүйцэтгэх, гарал үүслийг гэрчлэх, экспортлох үйл ажиллагааг эрхэлж байгаа этгээдийг биржийн арилжааны зах зээлд оролцогч гэнэ.

**53. Биржийн арилжааны зуучлагч ямар үйл ажиллагаа явуулах вэ?**

Биржийн арилжааны зуучлагч /брокер/ нь бараа, түүхий эдийг гэрээний үндсэн дээр биржээр зуучлан арилжих үйл ажиллагааг эрхэлнэ.

**54. Биржийн арилжаа гэж юуг хэлэх вэ?**

Биржийн арилжаанд оролцогчдын хооронд байгуулах

гэрээний үндсэн дээр бараа, түүхий эдийг худалдах, худалдан авах үйл ажиллагааг биржийн арилжаа гэнэ.

**55. Биржийн дэнчин гэж юу вэ?**

Биржийн арилжааны зуучлагч /брокер/ нь гэрээгээр хүлээсэн төлбөрийн үүргээ хэрэгжүүлэх баталгаа болгон биржийн төлбөр тооцооны байгууллага дахь өөрийн дансанд урьдчилан байршуулсан мөнгийг биржийн дэнчин гэнэ.

**56. Биржийн суудлын эрх гэж юуг хэлэх вэ?**

Биржийн арилжаанд тогтмол оролцох эрхийг биржийн суудлын эрх гэнэ.

**57. Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа биржийн арилжаанд оролцогч нь биржийн арилжаанд хэрхэн оролцох вэ?**

Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа биржийн арилжаанд оролцогч нь цахим сүлжээгээр дамжуулан биржийн арилжаанд шууд оролцож болно.

**58. Биржээр арилжих бараа, түүхий эдийн жагсаалт, бараа, түүхий эдийг коджуулах журмыг аль байгууллага батлах вэ?**

Биржээр арилжих бараа, түүхий эдийн жагсаалт, бараа, түүхий эдийг коджуулах журмыг хөдөө аж ахуй, худалдааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

**59. Биржээр арилжих бараа, түүхий эдийн жагсаалтад орсон бараа, түүхий эдийг экспортлоход ямар шаардлага тавигдах вэ?**

Биржээр арилжих бараа, түүхий эдийн жагсаалтад орсон бараа, түүхий эдийг экспортод гаргахдаа биржээр арилжаалсан байна.

**60. Бараа, түүхий эдийг биржийн арилжаанд оролцож худалдан авсан тухай тодорхойлолтыг үндэслэн хэнд урамшуулал олгох вэ?**

Бараа, түүхий эдийг биржийн арилжаанд оролцож худалдан авсан тухай тодорхойлолтыг үндэслэн дор дурдсан иргэн, хуулийн этгээдэд урамшуулал олгоно. Үүнд:

1. Хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл эрхлэгчдээс бүрдсэн хоршооны гишүүн;
2. Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч.

**61. Биржээс гадуурх бараа, түүхий эдийн арилжаанд биржийн нэр ашиглаж болох уу?**

Биржээс гадуурх бараа, түүхий эдийн арилжаанд биржийн нэр ашиглахыг хориглоно.

**62. Биржийн арилжаанд оролцох тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага болон биржийн үйл ажиллагаанд хяналт тавих журмыг аль байгууллага батлах вэ?**

Биржийн арилжаанд оролцох тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага болон биржийн үйл ажиллагаанд хяналт тавих журмыг Санхүүгийн зохицуулах хороо батална.

**63. Биржээр арилжих бараа, түүхий эдийн жагсаалтад орсон бараа, түүхий эдийг төсвийн хөрөнгөөр худалдан авах бол хэрхэх вэ?**

Биржээр арилжих бараа, түүхий эдийн жагсаалтад орсон бараа, түүхий эдийг төсвийн хөрөнгөөр худалдан авах бол биржээр дамжуулна.

**64. Бирж нь өөрийн нэрийн өмнөөс болон бусад оролцогчийн нэрийн өмнөөс биржийн арилжаанд оролцохыг хэрхэх вэ?**

Бирж нь өөрийн нэрийн өмнөөс болон бусад оролцогчийн нэрийн өмнөөс биржийн арилжаанд оролцохыг хориглоно.

**65. Бирж нь ямар нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх вэ?**

Бирж нь дараах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

* биржийн арилжааг зохион байгуулах;
* биржийн байнгын гишүүн оролцогчид суудлын эрх олгох;

* биржийн байнгын бус гишүүн оролцогчид биржийн арилжаанд оролцох зөвшөөрөл олгох;

* биржээр арилжих бараа, түүхий эдийн жагсаалтад орсон бараа, түүхий эдийг экспортод гаргах тохиолдолд биржээр арилжсан тухай тодорхойлолтыг Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай хуульд заасан экспортын барааны гарал үүслийг гэрчлэх эрх бүхий байгууллагад хүргүүлэх;

* биржийн арилжаанд оролцогчийг сургах, мэргэшүүлэх, итгэмжлэл олгох;

* биржийн арилжаанд оролцогчийг шаардлагатай мэдээллээр хангах;

* Хөдөө аж ахуй, худалдааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан биржээр арилжих бараа, түүхий эдийн жагсаалтад орсноос бусад нэр төрлийн бараа, түүхий эдийг биржээр арилжих жагсаалтыг батлах;

* биржийн арилжаанд оролцогчийн хүсэлтээр бараа, түүхий эдийн чанар, тоо хэмжээг хянан баталгаажуулж магадлагаа гаргах;

* биржийн арилжааны явцад зохиомлоор үнэ өсгөх, бууруулах оролдлого хийж байгаа эсэхэд хяналт тавих, таслан зогсоох;

* нэг хэлцлээр арилжих бараа, түүхий эдийн доод хэмжээг тогтоох;

* стандартын шаардлага хангасан агуулах, тээврийн байгууллага, лабораторит итгэмжлэл олгох.

**66. Бирж нь биржийн арилжааны зах зээлд оролцогчдын нийтлэг үйл ажиллагааг зохицуулсан ямар журмуудыг хэнээр хэлэлцүүлж батлуулан мөрдүүлэх вэ?**

Бирж нь биржийн арилжааны зах зээлд оролцогчдын нийтлэг үйл ажиллагааг зохицуулсан дор дурьдсан журмыг Биржийн зохицуулах зөвлөлөөр хэлэлцүүлэн баталж, мөрдүүлнэ:

* бараа, түүхий эдийг бэлтгэх, хаяглах, хадгалах, тээвэрлэх;

* бараа, түүхий эдийг бүртгэх;

* бараа, түүхий эдийг агуулахад хүлээн авах;

* биржээр арилжих гэрээний стандарт тогтоох, мөрдүүлэх;

* биржийн арилжааг зохион байгуулах;

* биржийн арилжааны үнэ бүрдэлтэд хяналт тавих;

* биржийн арилжааны төлбөр тооцоо хийх;

* мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах;

* биржийн арилжаанд оролцогчийн үйл ажиллагааг зохицуулах;

* стандартын шаардлага хангасан агуулах, тээврийн байгууллага, лабораторит итгэмжлэл олгох;

* биржээр арилжих бараа, түүхий эдийн гарал үүсэл, чанарыг баталгаажуулах;

* биржийн дэнчингийн хувь хэмжээг тогтоох;

* баталгааны санд биржийн дэнчин байршуулах, үүргийн гүйцэтгэлийг хангуулах;

* бусад.

**67. Бирж нь биржийн гэрээний төлбөрийн үүргийг тодорхойлох, төлбөр тооцоог гүйцэтгэх, гэрээг бүртгэх, хадгалах үйлчилгээг гэрээний үндсэн дээр ямар байгууллагаар гүйцэтгүүлэх вэ?**

Бирж нь биржийн гэрээний төлбөрийн үүргийг тодорхойлох, төлбөр тооцоог гүйцэтгэх, гэрээг бүртгэх, хадгалах үйлчилгээг гэрээний үндсэн дээр банк, үнэт цаасны төлбөр тооцооны байгууллагаар гүйцэтгүүлэх, эсхүл уг үүргийг гүйцэтгэх тусгайлсан нэгжтэй байна.

**68. Биржээр зориулалтын байранд, эсхүл цахим сүлжээг**

**ашиглан дуудлага худалдааны хэлбэрээр ямар төрлийн гэрээг арилжих вэ?**

Биржээр зориулалтын байранд, эсхүл цахим сүлжээг ашиглан дуудлага худалдааны хэлбэрээр дараах төрлийн гэрээг арилжина:

* шууд арилжих гэрээ /спот/;
* хугацаат гэрээ /форвард/;
* нэг загварын гэрээ /фьючерс/;
* ирээдүйд худалдах, худалдан авах гэрээ /опцион/.

**69. Шууд арилжих гэрээ гэж ямар гэрээг хэлэх вэ?**

Бараа, түүхий эдийг тогтоосон үнээр шууд, биет байдлаар нийлүүлэх гэрээг “шууд арилжих гэрээ” гэнэ.

**70. Хугацаат гэрээ гэж ямар гэрээг хэлэх вэ?**

Бараа, түүхий эдийг тогтоосон хугацаанд, тохиролцсон нөхцөлөөр, биет байдлаар ирээдүйд нийлүүлэх болон төлбөр гүйцэтгэх гэрээг “хугацаат гэрээ” гэнэ.

**71. Нэг загварын гэрээ гэж ямар гэрээг хэлэх вэ?**

Бараа, түүхий эдийг тогтоосон хугацаанд, тохиролцсон үнээр ирээдүйд нийлүүлэх стандарт нөхцөл бүхий гэрээг ”нэг загварын гэрээ” гэнэ.

**72. Ирээдүйд худалдах, худалдан авах гэрээ гэж ямар гэрээг хэлэх вэ?**

Тодорхой цаг хугацаа, эсхүл тодорхой үйл явдал болохоос өмнө ямар нэгэн зүйлийг худалдах, эсхүл худалдан авахаар гэрээний талууд тохиролцох буюу худалдан авагч талын санаачилгаар тодорхой эд хөрөнгийг олж авах эрхтэй байхаар байгуулсан гэрээг хэлнэ.

**73. Бирж нь биржийн арилжааны зах зээлд оролцогчдын үйл ажиллагаанд хяналт тавих, тэдгээрийн үйл ажиллагааг уялдуулах зорилготой ямар зөвлөлтэй байх вэ?**

Бирж нь биржийн арилжааны зах зээлд оролцогчдын үйл ажиллагаанд хяналт тавих, тэдгээрийн үйл ажиллагааг уялдуулах зорилготой орон тооны бус биржийн зохицуулах зөвлөлтэй байна.

**74. Зөвлөл ямар бүрэлдэхүүнтэй байх вэ?**

Зохицуулах зөвлөл 13 гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн 6 гишүүн нь үнэт цаас, хөдөө аж ахуй, худалдаа, зам, тээвэр, гааль, стандартчилал, чанарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын төлөөллөөс, 7 гишүүн нь биржийн арилжааны зах зээлд оролцогчдыг төлөөлсөн төрийн бус байгууллагын төлөөллөөс тус тус бүрдэнэ.

**75. Зөвлөлийн гишүүдийг хэн томилж чөлөөлөх вэ?**

Зохицуулах зөвлөлийн гишүүдийг хөдөө аж ахуй, худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын санал болгосноор Засгийн газар томилж, чөлөөлнө.

**76. Зөвлөлийн даргыг хэдэн жилийн хугацаагаар сонгох вэ?**

Зохицуулах зөвлөлийн дарга нь төрийн захиргааны байгууллагын төлөөлөл байх бөгөөд түүнийг зохицуулах зөвлөлийн гишүүдийн дотроос гишүүдийн олонхийн саналаар 3 жилийн хугацаагаар сонгоно.

**77. Зөвлөл ямар чиг үүрэгтэй байх вэ?**

Зохицуулах зөвлөл нь дараах чиг үүрэгтэй:

* “Хөдөө аж ахуйн гаралтай бараа түүхий эдийн биржийн тухай” хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэл өгөх;
* биржийн арилжааны зах зээлд оролцогчийн үйл ажиллагаанд хяналт тавих, тэдгээрийн үйл ажиллагааг уялдуулах;
* биржийн үйл ажиллагааны чиглэлээр зөвлөмж, дүгнэлт гаргах.

**78. Зөвлөлийн дүрэм, үйл ажиллагааны журмыг хэн батлах**

**вэ?**

Зохицуулах зөвлөлийн дүрэм, үйл ажиллагааны журмыг Засгийн газар батална.

**79. Зөвлөл хэнд үйл ажиллагаагаа тайлагнах вэ?**

Зохицуулах зөвлөл үйл ажиллагаагаа Засгийн газарт тайлагнана.

**80. Биржийн ажилтанд ямар үйл ажиллагаа явуулахыг хориглох вэ?**

Биржийн ажилтанд дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

* биржийн арилжаанд оролцох;

* брокерийн компани байгуулах;

* биржийн арилжаанд оролцогчийн арилжааны нууцыг агуулсан мэдээ, мэдээллийг хувийн ашиг сонирхолд ашиглах, бусдад задруулах;

* биржийн брокертой үгсэн хуйвалдаж биржийн арилжааг шударга бусаар явуулах;

* бараа, түүхий эдийн үнэд нөлөөлж болох мэдээллийг орхигдуулах, нуун дарагдуулах, зохих журмын дагуу мэдээлэл өгөхөөс татгалзах;

* ажил, үүргээ гүйцэтгэснийхээ төлөө бусад этгээдээс урамшуулал, мөнгөн шагнал, шан харамж авах.

**81. Биржийн арилжаанд оролцогчийг юу гэж ангилах вэ?**

Биржийн арилжаанд оролцогчийг байнгын болон байнгын бус гишүүн оролцогч гэж ангилна.

**82. Биржийн байнгын гишүүн оролцогч нь хэн байх вэ?**

Биржийн арилжааны зуучлагч /брокер/ нь үндэсний хөрөнгө оруулалт давамгайлсан хуулийн этгээд байх бөгөөд биржийн байнгын гишүүн оролцогч байна.

**83. Биржийн байнгын бус гишүүн оролцогч хэн байх вэ?**

Хоршоо нь байнгын бус гишүүн оролцогч байна.

**84. Биржийн байнгын гишүүн оролцогч биржийн арилжаанд оролцох тусгай зөвшөөрлийг хаанаас хэрхэн авах вэ?**

Биржийн байнгын гишүүн оролцогч биржийн арилжаанд оролцох тусгай зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хорооноос “Үнэт цаасны зах зээлийн тухай” болон “Хөдөө аж ахуйн гаралтай бараа түүхий эдийн биржийн тухай” хуульд заасан шаардлагыг хангасан тохиолдолд авна.

**85. Биржийн байнгын бус гишүүн оролцогч биржийн арилжаанд оролцох зөвшөөрлийг хаанаас авах вэ?**

Биржийн байнгын бус гишүүн оролцогч биржийн арилжаанд оролцох зөвшөөрлийг биржээс авсан байна.

**86. Биржийн арилжаанд ямар этгээдийг оролцохыг хориглох вэ?**

Биржийн арилжаанд дараах этгээдийг оролцохыг хориглоно:

* биржийн ажилтан;
* даатгал, тусламжийн сан, тэдгээрийн ажилтан;
* хууль тогтоомжоор аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхийг хориглосон бусад этгээд.

**87. Гадаадын иргэн, хуулийн этгээд, харъяалалгүй хүн биржийн арилжаанд хэрхэн оролцох вэ?**

Гадаадын иргэн, хуулийн этгээд, харъяалалгүй хүн биржийн арилжаанд биржийн байнгын гишүүн оролцогчоор зуучлуулан оролцоно.

**88. Хоршоо ямар байдлаар биржийн арилжаанд оролцох вэ?**

Хоршоо нь анхан шатны тордолт хийж стандартын шаардлага хангасан бараа, түүхий эдийг биет байдлаар нийлүүлэх гэрээ байгуулж биржийн арилжаанд оролцоно.

**89. Биржийн арилжаанд оролцогч ямар нийтлэг эрх, үүрэгтэй вэ?**

Биржийн арилжаанд оролцогч нь дараах нийтлэг эрх, үүрэгтэй:

* биржийн арилжааг ил тод, шударгаар явуулах;

* стандартын /бэлтгэх, хадгалах, тээвэрлэх, баглаа боодлын/ дагуу бэлтгэн сумын мал эмнэлэг, үржлийн тасагт бүртгүүлж, мэргэжлийн хяналтын байцаагчийн дүгнэлт гаргуулсан бараа, түүхий эдийг арилжих;

* бараа, түүхий эдийн чанар, тоо хэмжээг биржид үнэн зөв мэдээлэх, бүртгүүлэх;

* бараа, түүхий эдийн чанар, тоо хэмжээг биржид үнэн зөв мэдээлэх, бүртгүүлэх үүргээ биелүүлээгүйгээс худалдан авагчид учирсан хохирлыг тухайн арилжаанд оролцогч хариуцан барагдуулах;

* биржийн арилжааны мэдээллийг ашиглах;

* биржийн дүрэмд заасан бусад эрх, үүрэг.

**90. Биржийн байнгын оролцогч ямар эрх, үүрэгтэй вэ?**

Биржийн байнгын гишүүн оролцогч нь дараах эрх, үүрэгтэй:

* суудлын эрх авах;

* хуульд заасан төрлийн гэрээ байгуулсны үндсэн дээр биржийн арилжаанд тогтмол оролцох;

* бараа, түүхий эдийг хүлээн авах, хадгалах, бэлтгэх зориулалтын итгэмжлэгдсэн агуулахтай байх, эсхүл итгэмжлэгдсэн агуулах бүхий этгээдтэй гэрээ байгуулсан байх;

* биржийн арилжааны сүлжээнд холбогдсон байх;

* эрх бүхий байгууллагаас зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байх;

* итгэмжлэгдсэн лаборатори, тээврийн байгууллагатай

хамтран ажиллах гэрээ байгуулсан байх.

**91. Биржийн арилжаанд оролцогчийн ямар үйл ажиллагааг хориглох вэ?**

Биржийн арилжаанд оролцогчид дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

* биржийн арилжаанд оролцогч бусад этгээдийн болон түүний бараа, түүхий эдийн нэр хүндийг гутаах, эсхүл өрсөлдөгчөө алдагдалд оруулж болохуйц худал, зөрүүтэй буюу гуйвуулсан мэдээ тараах;

* харилцан тохиролцох замаар биржээр арилжих бараа, түүхий эдийн үнийн түвшинд хязгаар тогтоох;

* өөрийн болон биржийн арилжаанд оролцогч бусад этгээдийн бараа, түүхий эдийг үйлдвэрлэсэн арга, хэрэглээний шинж чанарын гол үзүүлэлт, хэрэглэх аргын талаар худал, зөрүүтэй мэдээлэх, эсхүл үнэн байдлыг гуйвуулах зэргээр бусдыг төөрөгдүүлэх, хуурч мэхлэх;

* хууль тогтоомжоор хориглосон бусад үйл ажиллагаа.

**92. Биржийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд ямар байгууллага аудит хийж дүгнэлт гаргах вэ?**

Биржийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд Үндэсний аудитын газар жил бүр аудит хийж дүгнэлт гаргана.

**93. Биржийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг олон нийтэд мэдээлэх үү?**

Биржийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ.

**94. Биржийн гэрээ байгуулах, түүнээс үүсэх эрх, үүрэгтэй холбогдон гарсан маргааныг хэрхэх вэ?**

Биржийн гэрээ байгуулах, түүнээс үүсэх эрх, үүрэгтэй холбогдон гарсан маргааныг эрх бүхий байгууллага хянан хэлэлцэж шийдвэрлэх бөгөөд уг шийдвэрийг эс зөвшөөрвөл талууд шүүхэд гомдол гаргаж болно.

**95. Биржтэй холбогдсон маргаантай асуудлыг арбитраар шийдвэрлүүлж болох уу?**

Биржтэй холбогдсон маргаантай асуудлыг арбитраар шийдвэрлүүлж болно.

**96. Биржийн нэр ашиглан бараа, түүхий эдийг худалдсан иргэн, хуулийн этгээдийг хэрхэх вэ? Хууль бусаар олсон орлогыг хураах уу?**

Биржийн нэр ашиглан бараа, түүхий эдийг худалдсан иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгож, хууль бусаар олсон орлогыг хураана.

**97. Биржийн арилжаанд хориглосон үйл ажиллагаа явуулсан биржийн байнгын болон байнгын бус гишүүн оролцогчийг хэрхэх вэ?**

Биржийн арилжаанд хориглосон үйл ажиллагаа явуулсан биржийн байнгын бус гишүүн оролцогчийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, байнгын гишүүн оролцогчийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, хууль бусаар олсон орлогыг хураах, энэ зөрчлийг давтан гаргавал бирж дээр үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг хүчингүй болгох арга хэмжээ авна.

**98. Хориглосон үйл ажиллагаа явуулсан биржийн ажилтныг хэрхэх вэ?**

Хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан биржийн ажилтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, үгсэн хуйвалдаж биржийн арилжаанд оролцсон оролцогчийн зөвшөөрлийг цуцлах, хууль бусаар олсон орлогыг хураах арга хэмжээ авна.

**99. Биржийн ажилтантай үгсэн хуйвалдаж биржийн**

**арилжаанд оролцсон оролцогчийг хэрхэх вэ?**

Үгсэн хуйвалдсан арилжаанд оролцогчийн зөвшөөрлийг цуцлаж, хууль бусаар олсон орлогыг хураана.

**100. Бараа, түүхий эдийн чанар, тоо хэмжээг үнэн зөв мэдээлж, бүртгүүлээгүйгээс биржийн арилжаанд оролцогчид учирсан хохирлыг хэрхэх вэ?**

Бараа, түүхий эдийн чанар, тоо хэмжээг үнэн зөв мэдээлж, бүртгүүлээгүйгээс биржийн арилжаанд оролцогчид учирсан хохирлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

------ооОоо------

**Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн төслийн нэгжийн танилцуулга**

Лхагваа Мөнбат
Төслийн нэгжийн захирал

Самбуу-Ёндон Баасанбаяр
Төслийн нэгжийн Менежер

Өлзиймаа Буяндэлгэр
Орон нутаг, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

Цэрэндорж Намхай
Бараа, түүхий эдийн коджуулалт, стандартчилалын мэргэжилтэн

Дэлгэрсайхан Энхдэлгэр
Бараа, түүхий эдийн тээвэрлэлт хадгалалт, стандарт хариуцсан мэргэжилтэн

Эрдэнэбат Цогбилиг
Судалгаа, мэдээлэл, хамтын ажиллагааны мэргэжилтэн

Жигжидсүрэн Жамъяндорж
Биржийн бэлтгэл ажил, сургалтын мэргэжилтэн

Пунцаг Золзаяа
Хуулийн зөвлөх, сургалтын мэргэжилтэн

Сэлэнгэ Орхонбаяр
Орон нутгийн сургалт хариуцсан мэргэжилтэн

Доржханд Осгонбаяр
Жолооч, туслах ажилтан

Төслийн нэгжийн хаяг: Баянзүрх дүүрэг
Энх тайваны өргөн чөлөө
ХАА Хоршоологчдын байр 18А/1, Өрөө 508
Улаанбаатар-49, Монгол улс
Утас/факс: (976)-11-452143
И-мэйл: info@mace.mn
Вэб сайт: www.mace.mn

# ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАРАЛТАЙ БАРАА,ТҮҮХИЙ ЭДИЙН БИРЖ

---

Эмхэтгэсэн: Ө.Буяндэлгэр
Хэвлэлийн эхийг бэлтгэсэн: Ч. Батболд
Эхийг "НОМ ХУР" ХХК-д бэлтгэж хэвлэв.
Утас/Факс:+976-11-31-5464, 31-4644
Хэвлэлийн хуудас: 3.5 х.х
Цаасны хэмжээ: 210х148 мм А5
Хэвлэсэн он: 2012 оны 01 сар
Хэвлэсэн тоо: 2000 ширхэг

НОМ ХУР
ХЭВЛЭЛ, ДИЗАЙН, РЕКЛАМНЫ ЦОГЦ ҮЙЛДВЭРЛЭЛ

ТЭМДЭГЛЭЛ

ТЭМДЭГЛЭЛ

# ТЭМДЭГЛЭЛ

# 2012

### НЭГДҮГЭЭР САР

| Да | Мя | Лха | Пү | Ба | Бя | Ня |
|---|---|---|---|---|---|---|
| 30 | 31 | | | | | **1** |
| 2 | 3 | 4 | 5 | 6 | **7** | **8** |
| 9 | 10 | 11 | 12 | 13 | **14** | **15** |
| 16 | 17 | 18 | 19 | 20 | **21** | **22** |
| 23 | 24 | 25 | 26 | 27 | **28** | **29** |

### ХОЁРДУГААР САР

| Да | Мя | Лха | Пү | Ба | Бя | Ня |
|---|---|---|---|---|---|---|
| | | 1 | 2 | 3 | **4** | **5** |
| 6 | 7 | 8 | 9 | 10 | **11** | **12** |
| 13 | 14 | 15 | 16 | 17 | **18** | **19** |
| 20 | 21 | 22 | 23 | 24 | **25** | **26** |
| 27 | 28 | 29 | | | | |

### ГУРАВДУГААР САР

| Да | Мя | Лха | Пү | Ба | Бя | Ня |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 1 | 2 | **3** | **4** |
| 5 | 6 | 7 | 8 | 9 | **10** | **11** |
| 12 | 13 | 14 | 15 | 16 | **17** | **18** |
| 19 | 20 | 21 | 22 | 23 | **24** | **25** |
| 26 | 27 | 28 | 29 | 30 | **31** | |

### ДӨРӨВДҮГЭЭР САР

| Да | Мя | Лха | Пү | Ба | Бя | Ня |
|---|---|---|---|---|---|---|
| 30 | | | | | | **1** |
| 2 | 3 | 4 | 5 | 6 | **7** | **8** |
| 9 | 10 | 11 | 12 | 13 | **14** | **15** |
| 16 | 17 | 18 | 19 | 20 | **21** | **22** |
| 23 | 24 | 25 | 26 | 27 | **28** | **29** |

### ТАВДУГААР САР

| Да | Мя | Лха | Пү | Ба | Бя | Ня |
|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | **5** | **6** |
| 7 | 8 | 9 | 10 | 11 | **12** | **13** |
| 14 | 15 | 16 | 17 | 18 | **19** | **20** |
| 21 | 22 | 23 | 24 | 25 | **26** | **27** |
| 28 | 29 | 30 | 31 | | | |

### ЗУРГААДУГААР САР

| Да | Мя | Лха | Пү | Ба | Бя | Ня |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | 1 | **2** | **3** |
| 4 | 5 | 6 | 7 | 8 | **9** | **10** |
| 11 | 12 | 13 | 14 | 15 | **16** | **17** |
| 18 | 19 | 20 | 21 | 22 | **23** | **24** |
| 25 | 26 | 27 | 28 | 29 | **30** | |

### ДОЛДУГААР САР

| Да | Мя | Лха | Пү | Ба | Бя | Ня |
|---|---|---|---|---|---|---|
| 30 | 31 | | | | | **1** |
| 2 | 3 | 4 | 5 | 6 | **7** | **8** |
| 9 | 10 | 11 | 12 | 13 | **14** | **15** |
| 16 | 17 | 18 | 19 | 20 | **21** | **22** |
| 23 | 24 | 25 | 26 | 27 | **28** | **29** |

### НАЙМДУГААР САР

| Да | Мя | Лха | Пү | Ба | Бя | Ня |
|---|---|---|---|---|---|---|
| | | 1 | 2 | 3 | **4** | **5** |
| 6 | 7 | 8 | 9 | 10 | **11** | **12** |
| 13 | 14 | 15 | 16 | 17 | **18** | **19** |
| 20 | 21 | 22 | 23 | 24 | **25** | **26** |
| 27 | 28 | 29 | 30 | 31 | | |

### ЕСДҮГЭЭР САР

| Да | Мя | Лха | Пү | Ба | Бя | Ня |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | **1** | **2** |
| 3 | 4 | 5 | 6 | 7 | **8** | **9** |
| 10 | 11 | 12 | 13 | 14 | **15** | **16** |
| 17 | 18 | 19 | 20 | 21 | **22** | **23** |
| 24 | 25 | 26 | 27 | 28 | **29** | **30** |

### АРАВДУГААР САР

| Да | Мя | Лха | Пү | Ба | Бя | Ня |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | **6** | **7** |
| 8 | 9 | 10 | 11 | 12 | **13** | **14** |
| 15 | 16 | 17 | 18 | 19 | **20** | **21** |
| 22 | 23 | 24 | 25 | 26 | **27** | **28** |
| 29 | 30 | 31 | | | | |

### АРВАННЭГДҮГЭЭР САР

| Да | Мя | Лха | Пү | Ба | Бя | Ня |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 1 | 2 | **3** | **4** |
| 5 | 6 | 7 | 8 | 9 | **10** | **11** |
| 12 | 13 | 14 | 15 | 16 | **17** | **18** |
| 19 | 20 | 21 | 22 | 23 | **24** | **25** |
| 26 | 27 | 28 | 29 | 30 | | |

### АРВАНХОЁРДУГААР САР

| Да | Мя | Лха | Пү | Ба | Бя | Ня |
|---|---|---|---|---|---|---|
| 31 | | | | | **1** | **2** |
| 3 | 4 | 5 | 6 | 7 | **8** | **9** |
| 10 | 11 | 12 | 13 | 14 | **15** | **16** |
| 17 | 18 | 19 | 20 | 21 | **22** | **23** |
| 24 | 25 | 26 | 27 | 28 | **29** | **30** |